

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

ХЯТАДЫН КОММУНИСТ НАМЫН VI ИХ ХУРАЛ**Д. Баясгалан**

Хятад дахь коммунист хөдөлгөөн болон хятадын хувьсгалт тэмцлийн түүхэнд нэн чухал байр суурь эзэлдэг ХКН-ын VI их хурал хуралдсаны 55 жилийн ой болж байна. Тус их хурал нь 1928 оны зургадугаар сарын 18-наас долдугаар сарын 11 хүртэл Москвад хуралдсан юм.

Энэ их хурал нь намын хувьд маш онцгой бэрхшээлтэй үед хуралдаж, ХКН-ын дотоод амьдралын олон чухал асуудлыг зөвөөр шийдэж, намын эгнээг нягтруулж, цаашид өсөн бойжиход нь ихээхэн ач холбогдолтой болсон тухай тухайн үеийн баримт бичигт тодорхой дурьджээ.¹ 1925—1927 онуудын хувьсгалын хүнд ялагдал нь ажилчин ангийн улс төрийн идэвхийг уналтанд хүргэж, олон түмний дундах ХКН-ын нөлөөг бууруулсан юм. Олон тооны коммунистууд харгис хэрцгий хядлагын золиос болсон ба хувьсгалын эхэн үед ХКН-ыг аялдан дагалдаж ирээд шургалсан тогтворгүй элементүүд намаас хөндийрч эхэлжээ. Түүний зэрэгцээгээр хувьсгал хүчтэй өрнөж, ялалт олж байсан хөдөөгийн хэд хэдэн районуудад пролетари ангийн эрх ашгаас татгалзсан зүсэн зүйлийн хүчнүүд шургалах нь олон болжээ.²

Хямралын энэ үзэгдэл нь намын стратеги, тактикийн үндсэн асуудлаар өөр хоорондоо зөрөлдөж байсан ХКН-ын удирдлагад хүртэл нөлөөлсөн байна.

Чухам ийм нэн ээдрээ түвэгтэй нөхцөлд коммунист интернационалаас ХКН-д их туслалцаа үзүүлжээ. 1928 оны 2-р сард болж өнгөрсөн Коминтерний гүйцэтгэх хорооны IX бүгд хурлаас «хятадын асуудлаар» тусгай тогтоол гаргаж, хятадын хувьсгалын тухайн үеийн байдалд үнэлэлт өгч, хятадын хувьсгалын онцлог, түүний шинж чанар, ангийн хүчний байршилт намын тактикийн талаар онцгой анхаарлыг тавьсан ажээ.

Коминтерний IX бүгд хурлын баримт бичигт ХКН-ын байр суурийг тодорхойлж тэмдэглэхдээ ... Хятадын хувьсгалын одоо үе нь эдийн засгийн/ газар тариалангийн эргэлт ба феодалын харилцааг устгаагүй/ талаас ч империализмын эсрэг үндэсний тэмцлийн (үндэстний тусгаар тогтнол ба Хятадыг нэгтгэх) талаас ч засаг төрийн ангийн чанарын (пролетарийн диктатур ба тариачдын) талаас ч боловсроогүй хөрөнгөтний ардчилсан хувьсгалын үе юм.³ гэж үзээд цааш нь заахдаа ... тухайн үе шатны шинж байдал нь хувьсгалын хувьд социалист хувьсгал болон хувьссан гэвэл ч буруу. Ийм байдлаар үргэлжилсэн

¹ О. М. Миткевич. Компартия Китая. В кн. Партии Коммунистического Интернационала. Справочник пропагандиста. М—А. 1928, с. 158—170

² В. И. Глунин. V съезд КПК и уроки революции 1925—1927 гг.—«Проблемы Дальнего Востока», 1977, № 2, с. 141.

³ Стратегия и тактика коминтерна в национально-колониальной революции на примере Китая, Сборник документов. М—Л, 1934, с. 207.

хувьсгал хэмээн түүний шинж байдлыг тодорхойлох нь нэгэн адил буруу юм...⁴ гэжээ.

Коминтерний Гүйцэтгэх хорооны бүгд хурлаас тухайн үеийг хувьсгалын давалгааны уналт гэж үзээд, янз бүрийн муж хязгаарт хувьсгалт хөдөлгөөний хөгжилт туйлын жигд биш бөгөөд ажилчны хөдөлгөөн нь тариачны хөдөлгөөнөөс мэдэгдэхүйц хоцорч явааг зааж өгчээ.

Коминтерний Гүйцэтгэх хорооноос намын тактикийн шугамыг тодорхойлон тэмдэглэхдээ «... Намын бүхий л ажлын гол гогцоо нь одоо цагт ажилчин, тариачин сая сая олон түмнийг өөртөө татан тэднийг улс төрийн хувьд гэгээрүүлж бас тэдгээрийг нам ба түүний лозунг хүрээлүүлэх хүртэл зохион байгуулахад оршиж байна...»⁵ гэжээ.

Хувьсгалт зөвлөлд нэгдсэн тариачны район дахь ХКН-ын гол бодлого нь «Газар тариалангийн шинэчлэлийг явуулж, улаан армийн ангиудыг зохион байгуулах нь чухал бөгөөд тэдгээр ангиуд нь яваандаа нэгдэж нэгдсэн бүх хятадын улаан арми болно гэдэг тооцоог⁶ хийсэн байна. Тус бүгд хурлаас, гэнэт төрийн эргэлт хийхийн эсрэг хувьсгал хийхдээ зүүний сүржин үг яриагаар цаг нөхцөөхийн эсрэг хоосон манлайлах болон хүчирхийлэн ажил хаялт хийлгэхийн эсрэг шийдвэртэй тэмцэхийг ХКН-аас уриалсан байна. Гоминьданы харгислал ихсэж, хувьсгалыг багалзуурдан дарахын тулд аллага хядлага үйлдэж байсан хятадын хувьсгалын их хугаралтын үед Коминтерны санаачлагаар ХКН-ын VI их хурлыг Москвад хуралдуулахаар шийдвэрлэсэн нь учиртай ажээ.

1928 оны хавраас их хурлын бэлтгэл ажлыг хийж юуны өмнө их хурлаас гарах үндсэн шийдвэрийн төслийг боловсруулж ялангуяа газар тариалан, тариачны асуудал болон цэргийн ажлын талаар гарах тогтоол шийдвэрийн төслийг нэн түрүүн боловсруулж эхэлжээ. Их хуралд бэлтгэж, намын их хуралд сонгогдон оролцох төлөөлөгчдөд тусгайлан зориулж бэлтгэсэн «Зэвсэгт бослого» хэмээх номыг орчуулан, Ван Мин оршил бичиж хэвлэн тараажээ. Уул номонд орос, герман, болгар болон хятадын хувьсгалын туршлага, олон түмний зэвсэгт тэмцлийн туршлагыг нэгтгэн дүгнэсэн байна.

Мөн хуралд бэлтгэх ажлын нэг чухал хэсэг нь Москвад урьдчилан ирж байсан ХКН-ын удирдах хүмүүс Коминтерний Гүйцэтгэх Хорооны тэргүүлэгч гишүүд, коминтерний бусад ажилтнуудтай уулзалт хийх явдал байжээ.

Их хурлын 20 гаруй өдрийн хуралдаан Москва мужийн Нарофоминскийн районы Первомайск сууринд болжээ. Их хуралд намын 40,000 төлөөлөгчийг төлөөлөн таслах эрхтэй 84, зөвлөх эрхтэй 31 төлөөлөгчид оролцсоны 60% илүү нь ажилчин ангийн төлөөлөгчид байжээ.⁷

Их хуралд оролцогчдод коминтерн, КИМ, БХК (б) Нам, Италийн коммунист нам, Бүх хятадын үйлдвэрчний эвлэлийн холбоо, ХКЗЭ-ийн төлөөлөгчид баяр хүргэжээ. Их хурлаар «Олон улсын байдал ба ХКН-ын зорилт» гэсэн коминтерний төлөөлөгчийн илтгэл, Цюй Цюбо-гийн тавьсан ХКН-ын Төв Хорооны тайлан илтгэл, Сянь Чжунфагийн Коминтерний Гүйцэтгэх Хорооны IX бүгд хурлын шийдвэрийн тухай илтгэл, Чжоу Эньлайн цэргийн асуудал ба зохион байгуулалтын ажлын

⁴ Мөн тэнд,

⁵ Мөн тэнд. с .208.

⁶ Стратегия и тактика Коминтерна п национально-колониальной революции на примере Китая. Сборник документов. М—Л. 1934. с .208.

⁷ А. М. Григорьев. Важная веха в истории КПК.—«Проблемы Дальнего Востока», 1973, № 2 с. 102,

тайланг тус тус авч хэлэлцжээ. Мөн үйлдвэрчний эвлэлийн ажлын талаар интернационалын үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгч Сянь Чжунфагийн сонсгол, тариачны хөдөлгөөн ба газар тариалангийн программын талаар Ли Лисаны сонсголыг сонсон хэлэлцжээ. Их хурал дээр хэлэлцсэн асуудал бүрээр зохих тогтоолуудыг гаргажээ.

Тус их хурлаас хятадын хувьсгалын шинж чанарыг хөрөнгөтний ардчилсан хувьсгал гэж үзээд империализмын эсрэг тэмцэж үндэсний тусгаар тогтнолоо олж улс орноо нэгтгэх, феодализмын үр дагавар ба газрын эздийн газар ззэмшлийг устган газар тариалангийн хувьсгалыг явуулах, гоминьданы дэглэмийг түлхэн унагаж, ажилчин тариачин, цэргийн депутатуудын зөвлөлийн хэлбэртэй ажилчин анги ба тариачны хувьсгалт ардчилсан диктатурыг тогтоох зэрэг үндсэн зорилтууд оршиж байгаа тухай коминтерний үнэлгээг бүрэн, дүүрэн зөвшөөрч байгаагаа мэдэгдсэн байна.⁸

Тэр үед ХКН-ын дотор хувьсгалын төлөв байдал, шинж чанарыг үзэх талаар зүүний ойлголт их дэлгэрснийг харгалзан үзээд их хурлаас онцлон тэмдэглэхдээ «хувьсгалын одоогийн үе шатыг социалист болон хувирлаа гэх буюу, түүнчлэн хятадын хувьсгал нь үргэлжилсэн гэж үзэх нь алдаатай хэрэг юм»⁹ гээд «хувьсгалт хөдөлгөөний хөгжлийн хурдац жигд бус»¹⁰ байна гэжээ.

Дийлэнх олон ард түмэнтэй холбоотойгоор тэдний төлөө тэмцэх тэмцэл бол намын бодлогын жанжин шугам мөн гэж их хурлаас үзээд энэхүү тэмцлийн амжилт нь ХКН-ын дотор мэр сэр оршин байгаа яаравчлан төрийн эргэлт хийх үзэл, дайны хэнээрхэл туссан үзэл бодлоос шийдвэртэй салж, олон түмэн ялангуяа ажилчин ангийн хувьд тушаах ба албадлагыг хэрэглэх арга барилаа өөрчлөхөөс хамаарагдана гэж тэмдэглэжээ. Чухам ингэж их хурлын баримт бичгүүдэд пролетари олонхийн төлөө тэмцэх тэмцлийг ХКН-ын ажилчин ангийн талаар баримтлах гол бодлого болгон дэвшүүлжээ. Мөн «тариачны хөдөлгөөн дэх пролетариудын удирдах ролийг хүчтэй болгогч»¹¹ аж үйлдвэрийн ажилчны үйлдвэрчний хөдөлгөөнд онцгой анхаарал тавих хэрэгтэй байлаа.

Их хурал нь хувьсгалт үйлдвэрчний эвлэлүүдийг сэргээх ба удирдах ажлыг дээд зэрэгт нь хөгжүүлэхийг шаардаад ажилчин олон түмний өдөр тутмын шаардлагыг хичээнгүйлэн анхаарч байхыг уриалан энэ асуудлаархи намын улс төр, эдийн засгийн үндсэн лоозонг¹² тодорхойлжээ.

Их хурал газар тариалан, тариачны асуудалд онцгой анхаарал тавьжээ.¹³

Хөдөө тосгон дахь хувьсгалт тэмцлийн асуудлаар их хурлын баримт бичигт «улс төрийн шийдвэр» хэмээх тусгай бүлэг зориулснаас гадна «газар тариалангийн асуудлаар гаргах шийдвэр», «тариачны хөдөлгөөний тухай шийдвэр», «Зөвлөлт засгийг байгуулах тухай шийдвэр» зэрэг бусад баримт бичгүүдийг гаргажээ. Газар тариалан, тариачны асуудлаархи их хурлын шийдвэрт хятадын тосгон дахь нийгэм

⁸ Программные документы коммунистических партии Востока. М., 1934, с. 15—16

⁹ Политическая революция. с. 15—16.

¹⁰ Политическая революция. с. 22

¹¹ Политическая революция с. 29

¹² Революция по профдвижению-стенографический отчет VI съезда Коммунистической партии Китая. КН. 6.

¹³ Л. П. Делюсин- Аграрно-крестьянский вопрос в политике КПК. (1921 1928) М., 1972, с. 376-439.

эдийн засгийн харилцааны талаар дэлгэрэнгүй шинж чанарыг тодорхойлж тариачны тэмцлийн үндсэн хэлбэр, хэв маяг, шинж чанарт дүн шинжилгээ хийж, тариачны хөдөлгөөний талаар ХКН-ын стратеги, тактикийг боловсруулан тодорхойлжээ.

Их хурлаас газрын эздийн газрыг булаан авч газаргүй буюу бага газартай тариачдад шилжүүлж өгнө гэсэн гол уриаг дэвшүүлээд уул ажлын стратегийн чиг шугамыг заан гаргажээ. Тосгон дахь хувьсгалын гол дайсан бол газрын эзэд, нударган баячууд мөн бөгөөд пролетари нарт тулгуур болох хүч нь ядуучууд, дундчууд мөн. Гэхдээ нударганчуудын эсрэг тэмцэх тэмцлийг ялган салгах, гэнэт хурцатгаж болохгүй гэдгийг тодорхойлон заажээ. Эн түрүүнд помещик анги ба тариачдын хоорондын үндсэн зөрчлийг арилгана. Гэвч, энэ нь газрын эзэд ба нударганчуудтай хийх ангийн тэмцлээс ухарна гэсэн үг биш юм»¹⁴ гэж үзжээ.

ХКН-ын VI их хурлаас ХКН-ын удирдлагын дор тариачныг зохион байгуулж, тэдний тэмцлийн бүхий л хэлбэрийг ашиглан, партизани хөдөлгөөний удирдлагыг боловсронгуй болгон хөдөө орон нутагт намын зэвсэгт хүчнийг байгуулах нь чухал гэж үзжээ. Мөн газар тариалангийн хувьсгалын тухай гол лоозонг олонхи тариачдын хувийн шаардлагатай холбогдон гарч буй тэмцэлтэй чадварлагаар уялдуулах тухай намын бодлогын чигийг гаргаж өгсөн байна.

ХКН-ын VI их хурлын хэлэлцэх асуудалд цэргийн асуудлыг оруулан авч хэлэлцсэн билээ. Чжоу Энълайн тавьсан цэргийн асуудлын тухай илтгэлд цэргийн талаар баримталж буй намын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж тухайн үеийн бодит байдалд задлан шинжилгээ хийсэн байна. Тухайлбал, илтгэгч илтгэлдээ Мао Зэдуны цэргийн шинж чанарыг тодорхойлж хэлэхдээ «Тэр арми нь заримдаа дээрэмчний шинжтэй мэт байна. Харин Зөвлөлийг байгуулах ба газар тариалангийн хувьсгал хийх тухайд тэд хэрхэн хандаж байгааг бид одоо мэдэхгүй байна»¹⁵ гэжээ.

Цэргийн асуудлаар гаргасан их хурлын баримт бичгүүдэд улаан армийг байгуулах, түүний стратеги, тактикийг тодорхойлох, захирагчид ба улс төрийн ажилтныг сонгон авах, байгуулагдаж буй зэвсэгт хүчний дунд намын удирдах ролийг өндөржүүлэх талаар онцгой анхаарал тавьжээ.

Их хурал нь ХКН-ын зохион байгуулалтын ажлын явц, байдалд бас онцгой анхаарал тавьжээ. Тэр үед намын байгуулалтын ажлын учир дутагдлаас болж нам, олон түмний хоорондын холбоо суларсан байв. Ийм байдал маш аюултай болохыг их хурал заагаад, «намын нэн тэргүүний зорилт нь аж үйлдвэрийн чухал салбаруудад нэвтрэн орж, тэнд зохион байгуулалтын хувьд бэхжих» нь чухал гэж тодорхойлжээ. Энэ мэтээр нам нь аж үйлдвэрийн пролетари нарт тулгуурлан өсч өргөжих ба аажмаар пролетари ангийн элементүүд намын суурь болж ирэх ёстой гэж үзжээ. Түүнчлэн, хөдөө тосгоны намын байгууллага дахь нийгмийн бүрэлдэхүүнийг нэгэн адил зохицуулах зорилтыг тавиад «тосгоны ядуучууд ба пролетари элементүүдээс намын эгнээ өргөжиж байх»¹⁶ гэдгийг заажээ.

Их хурлаас намын удирдах байгууллагад идэвхтэй ажилчдыг татан оролцуулж байхын чухлыг тэмдэглэжээ.

¹⁴ Политическая резолюция. с . 29-30

¹⁵ Стенографический отчет VI съезда Коммунистической партий Китая. КН. 5. с . 13.

¹⁶ Стенографический отчет VI съезда КПК. КН. 6.

Ажилчин бус гаралтай гэдэг шалтгаанаар хүмүүсийг ажлаас нь зайлуулж байсан намын зарим байгууллагын алдааг сэргийлэн анхааруулаад намын гишүүн хүний үнэлгээний шалгуур нь түүний улс төрийн тэсвэр, сахилга бат, ажилчин ангийн ашиг сонирхолд үнэнч байх, ажилчин тариачин өргөн олон түмэнтэй холбоотой байх, олон түмэнд нөлөөлөх чадвартай, олон түмнийг араасаа дагуулж чадах авьяас чадвартай, байхыг тэмдэглэжээ.

Намын ажилд аппаратын хүнд суртлын хэлбэр байна гэж зарим хүнийг нэрлэн заагаад хамтын ажиллагаа алга шахам байна гэж дүгнэжээ. Түүнчлэн намын дотор намын ажилтны үйл ажиллагаанд ардчилсан хэлбэр хөгжөөгүй, бүлгэрхэх, зарчимгүй маргалдах, тэр ч байтугай санаа тасрахгүй хүмүүстэйгээ эрх чөлөөнд нь халдах явдал байна гэдгийг их хурлаас анхааруулсан байна.

Ийм нөхцөл байдалд юуны өмнө намын зохион байгуулалтын ажлыг үндсээр нь өөрчлөн сайжруулж намын эгнээний доторхи эрүүл бус аливаа үзэгдлийг шийдвэртэйгээр даван туулахыг их хурлаас шаарджээ

ХКН-ын VI их хурал дээр ХКН-ын шинэ дүрмийн төслийг хянан хэлэлцэхдээ намын урьдах дүрмийн зарим нэг томъёололыг засварласан байна. Үүнд, намын удирдах байгууллагын ба намын гишүүний тухай асуудлыг оруулж, удирдлагын хамтын ажиллагааг хангах болон намын дотоод ардчилалыг хөгжүүлэх зорилгоор ХКН-ын их хурлыг жил бүр хуралдуулж байхаар тогтсон байна.¹⁷

Уг их хурлаас намын шинэ удирдлагад ХКН-ын программын төслийг бэлтгэж дараагийн их хуралд хэлэлцүүлж батлуулах, улмаар эл программд хятад дахь үндэстний цөөнхийн асуудлыг тусгай бүлэг болгон оруулахаар шийдвэрлэжээ. Их хурлын төлөөлөгчдөөс Намын Төв Хорооны шинэ бүрэлдэхүүнд «Улс төрийн шийдвэр»-ийн үндсэн-дээр «их хурлын тунхаглал» бэлтгэхийг даалгажээ.

Мөн их хурлаас 12-р сарын 11-ний өдрийг Кантоны коммуны өдөр болгосон шийдвэр гаргажээ.¹⁸

Их хурлаас ХКН-ын Төв Хорооны шинэ бүрэлдэхүүнийг 23 гишүүн, 13 орлогч гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгожээ. ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар Сянь-Жунфаг сонгожээ.

ХКН-ын VI их хурал нь Хятадын хувьсгалын үндсэн асуудал ба намын стратеги, тактикийг боловсруулахад чухал алхам болсон байна.

Их хурлын шийдвэр нь ХКН-ын үйл ажиллагааны бүхий л салбарыг бараг хамарсан бөгөөд үнэн чанартаа анхны дэлгэрэнгүй программ болсон юм. Их хурлын баримт бичгүүдэд газар тариалангийн хувьсгалын тухай, социализмын үндэс байгуулах тухай, хөдөө орон нутагт зэвсэгт хүчнийг зохион байгуулж партизаны тэмцлийг бэхжүүлэх, ХКН-ын удирдлагын дор тариачны дайныг хийх зэрэг асуудлыг томъёолж өгсөн нь онцгой ач холбогдолтой болсон ажээ.

Уг их хуралд Мао Зэдун оролцоогүй байна. Их хурлаас тухайн үед Мао Зедуны ажил явууллагыг «милитарист сэтгэл зүйн илрэл»¹⁹ гэж тодорхойлжээ. Гэтэл өнөөгийн Бээжингийн суртал нэвтрүүлэгч, түүхчид Маогийн биеэрээ оролцоогүй ХКН-ын түүхийн аливаа үйл явдлыг хятадын хувьсгалын хэрэгт хортой гэх буюу дор хаяад л ач холбогдол багатай гэж тайлбарлаж байна. Тухайлбал Ху Хуагийн бичсэн «Хятадын хувьсгалын тухай лекц», мөн «ХКН-ын товч түүх» зэрэг зохиол болон

¹⁷ Устав Коммунистической партии Китая. М.. 1937, с, 20.

¹⁸ Стенографический отчет VI съезда КПК. Революции.

¹⁹ О. Владимиров. В. Рязанцев. «Мао Зедуны улс төрийн үйл ажиллагааны намтрын хуудсууд» УБ.. 1974 он. 35-р тал.

«Жэньминь жибао» сонин зэрэг албаны сонин хэвлэлд бичсээр байна.²⁰

ХКН-ын VI их хурал нь хятадын хувьсгалын маш эгзэгтэй үед хуралдаж олон чухал шийдвэр гаргаж, ХКН-нь цаашдын өсөлт бойжилт, хятадын хувьсгал өргөжин хөгжиж ялалт олоход нэмэр хандив болсон билээ. Гэтэл Мао Зэдуны талын үндсэрхэх үзэлтэй намын удирдах ажилтнууд их хурлын үзэл санааг гажуудуулж, ач холбогдлыг нь бууруулсаар байв. Их хурлын дүрэмд намын их хурлыг тухайн үеийн онцгой нөхцөлд жилд нэг удаа хуралдуулахаар заасан билээ. Гэтэл VI их хурлаас хожим VII их хурал хүртэл 17 жил болсон билээ. VI их хурлаас хойш хятадын хувьсгал өрнөж ХКН-ын эгнээ өргөжсөн юм. Энэ чухал их хурлын шийдвэр, ач холбогдлыг зөвөөр үнэлэх нь зайлшгүй шаардлагатай билээ.

²⁰ Ху Хуа. «Хятадын хувьсгалын түүхийн лекц» Бээжин 1980. (хятадаар) 278—279-р тал. Жэньминь жибао. 1982. 8. 30. «ХКН-ын түүхийн лекц» Жилин хот. 1981. (хятадаар)